

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
	2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
	2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
	2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	13
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	14
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	15
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ СОЛОНГОСЫН ДОРНЫН
АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Л.ЖАМБАЛЖАВ ТАНАА

2020.03.13 № 06/787
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн захирал Л.Жамбалжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн удирдлага нь санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 03-наас 2020 оны 3 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, сургалт, судалгаа явуулах гэж тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дорнын анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт судалгаа явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Microsoft Excel” программ хангамж ашигладаг байна.

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар
Монгол

Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд 4 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 71.4 сая төгрөгөөс тооцон 7.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон 2.0 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг ажил гүйлгээний тоо хэмжээ болон эрсдэлийн түвшин “бага” зэргээс хамаарч тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.3 сая төгрөгөөр буюу 0.29 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.0	0.4	(2.6)
Авлага	-	-	-
Бараа материал	2.0	0.8	(1.2)
Үндсэн хөрөнгө	80.7	66.2	(14.5)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	4.0	4.0	-
Нийт хөрөнгө	89.7	71.4	(18.3)
Өр төлбөр	32.0	8.6	(23.4)
Эздийн өмч	57.7	62.8	5.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	89.7	71.4	(18.3)

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал болон 11.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр 23.4 сая төгрөгөөр буурсан нь дансны өглөгийг 30.0 сая төгрөгөөр барагдуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн 4.2 сая, татварын 2.3 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 62.8 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан ашгийн өсөлт байна.

2.9. Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв нь тайлант онд 324.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 319.2 сая төгрөгийг зарцуулж, 5.1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Орлого өмнөх оноос 31.4 сая төгрөгөөр, зардал 30.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь “Оргил рашаан сувилал” ТӨХК-г хувьчилснаас тус төвийн байр хувьчлагдаж хэвтэн эмчлүүлэх тасаг ажиллах боломжгүй болсноос борлуулалтын орлого, зардал буурсан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Барилгыг өөрийн өмчлөлд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх, газар болон барилгын доорх газрын асуудлыг зохих байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл дэх мэдээллийг байршуулах шаардлагагүй гэж Эрүүл мэнд яам үзсэн байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 2.8 сая төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тооцсон 7.0 сая төгрөгийн материаллаг байдлын дүнгээс бага тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1.1 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тус байгууллага 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг холбогдох дээд байгууллагаар батлуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21.1-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, мөн санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байгууллагын статус тодорхойгүй байгаагаас төсөв төлөвлөгөөг баталж өгдөггүй.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

3.2.2 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлангаа хэрэглээний “Excel” программ ашиглан бэлтгэж байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.3 Эрсдэл: Нягтлан бодогчийн ачаалал ихсэх, алдаа гарах магадлалтай, Үнэн зөв байх батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх,

3.2.4 Өгсөн зөвлөмж: Сангийн яамнаас зөвшөөрөгдсөн Нягтлан бодох бүртгэлийн программыг авч ашиглах

3.2.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.3.2 Илрүүлэлт: Бүгд Найрамдах Солонгос Улсаас худалдан авсан 2.8 сая төгрөгийн эмийн түүхий эдийн тээврийн зардлыг бүтээгдэхүүний өртөгт оруулаагүй, шууд тээврийн зардалд бүртгэсэн. Энэ нь НББОУС 2-ыг зөрчсөн байна.

3.3.3 Эрсдэл:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,
- Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх,
- Тайлант хугацааны үр дүн зөрүүтэй илэрхийлэгдэх,
- Бүтээгдэхүүний өртөг буруу тооцогдох,

3.3.4 Өгсөн зөвлөмж: НББОУС 2-ын дагуу импортоор авсан эмийн түүхий эдийн зардлыг бүтээгдэхүүний өртөгт шингээн тооцож байх,

3.3.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Жилдээ 2 удаа татан авалт хийдэг тул өртөг бүртгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн ба зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт: Худалдан авалт хийхдээ “И” баримт бүртгүүлж аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэл тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Татварын ерөнхий хуулийн 41.7.3-т “цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, олгох, илгээх, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,
- Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх,

3.4.3 Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийх бүрдээ “И” баримт бүртгүүлж ажиллах,

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Худалдан авалт хийхдээ “И” баримт бүртгүүлж, өгсөн зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,980,382.80	347,325.63
1.1.6	Бараа материал	2,045,258.00	860,093.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,025,640.80	1,207,418.63
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	80,673,330.97	66,244,539.97
1.2.2	Биет бус хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	84,673,330.97	70,244,539.97
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	89,698,971.77	71,451,958.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	30,000,000.00	-
2.1.1.3	Татварын өр	1,960,108.84	4,328,100.31
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	4,238,765.56
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,960,108.84	8,566,865.87
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	31,960,108.84	8,566,865.87
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	60,387,091.00	60,387,091.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	3,252,387.00	3,252,387.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	67,930,200.00	67,930,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(73,830,815.07)	(68,684,585.27)
2.3.11	Эздийн өмчийн дүн	57,738,862.93	62,885,092.73
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	89,698,971.77	71,451,958.60

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	356,123,100.00	324,950,840.00
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	356,123,100.00	324,950,840.00
8	Бусад орлого	210,000.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	349,424,664.86	318,520,254.88
12	Бусад зардал		712,552.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,908,435.14	5,718,033.12
19	Орлогын татварын зардал	690,843.51	571,803.32
20	Татварын дараах ашиг (алдагдал)	6,217,591.62	5,146,229.80
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,217,591.62	5,146,229.80
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	6,217,591.62	5,146,229.80
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	60,387,091.0	3,252,387.0		67,930,200.0	(82,497,100.63)	49,072,577.37
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					2,448,693.94	2,448,693.94
3	Залруулсан үлдэгдэл	60,387,091.0	3,252,387.0		67,930,200.0	(80,048,406.69)	51,521,271.3
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					6,217,591.62	6,217,591.62
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	60,387,091.0	3,252,387.0		67,930,200.0	(73,830,815.07)	57,738,862.93
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
11	Залруулсан үлдэгдэл	60,387,091.0	3,252,387.0		67,930,200.0	(73,830,815.07)	57,738,862.93
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					5,146,229.8	5,146,229.8
13	Бусад дэлгэрэнгүй орлого						
14	Өмчид гарсан өөрчлөлт						
15	Зарласан ногдол ашиг						
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
17	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	60,387,091.0	3,252,387.0		67,930,200.0	(68,684,585.27)	62,885,092.73

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	354,453,290.00	326,320,629.70
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	353,898,911.00	322,467,758.50
1.1.6	Бусад мөнгөн орлого	554,379.00	3,852,871.20
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	343,096,748.25	296,994,086.87
1.2.1	Ажиллагчдад төлсөн	131,092,566.80	145,078,041.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,631,124.45	37,402,211.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	67,133,013.00	46,347,024.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	49,168,898.00	24,648,226.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,149,195.00	12,993,400.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	15,000,000.00	10,786,058.47
1.2.9	Бусад мөнгөн зарлага	19,921,951.00	19,739,126.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,356,541.75	29,326,542.83
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	31,959,600.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,000,000.00	31,959,600.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,000,000.00)	(31,959,600.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,356,541.75	(2,633,057.17)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,623,841.05	2,980,382.80
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,980,382.80	347,325.63

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	МСДАУТ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.10			САГ-2020/103/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төв” ТӨҮГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн сая.төг	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1		2	3	4	5
1	Тус байгууллага 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг холбогдох дээд байгууллагаар батлуулаагүй байна.	-	Зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Жамбалжав Д.Ганчимэг
2	Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлангаа хэрэглээний “Excel” программ ашиглан бэлтгэж байна.	-	Зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Жамбалжав Д.Ганчимэг
3	Бүгд Найрамдах Солонгос Улсаас худалдан авсан эмийн түүхий эдийн тээврийн зардлыг бүтээгдэхүүний өртөгт оруулаагүй, шууд тээврийн зардалд бүртгэсэн.	2.8	Зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Жамбалжав Д.Ганчимэг
4	Худалдан авалт хийхдээ “И” баримт бүртгүүлж аваагүй байна.	-	Зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Жамбалжав Д.Ганчимэг
Нийт дүн		2.8			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 28 lines spaced evenly down the page.